

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

"Хөвсгөл Эрчим хүч" ХХК-ийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн
аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2024/011/НА-СТА-ОНА

Цахим хуудас:
www.audit.mn

Хөвсгөл аймаг
2024 он

Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatar@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Давааням
Утас: 92113932 Цахим хаяг: davaanyamb@audit.gov.mn

Аудитор: Л.Мөнх-Оргил
Утас: 99039344 Цахим хаяг: orgil.ikhuul@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан.....	5
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	0
2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	0
3. Аудитын тайлан.....	0
3.1 Компани, түүний үйл ажиллагаа.....	1
3.2 Компанийн гадаад дотоод орчин.....	1
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	2
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	3
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл.....	4
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	6
4.1 Ерөнхий зүйл.....	6
4.2 Материаллаг байдал.....	7
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	7
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	7
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	7
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	9
4.5.1 Завсрын аудитын талаар.....	9
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	10
5. Аудитын илрүүлэлт.....	10
5.2 Төлбөрийн акт.....	10
5.3 Албан шаардлага.....	10
5.4 Зөвлөмж.....	11
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	12

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
ЦДАШ	Цахилгаан дамжуулах агаарын шугам
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл

Хөвсгөл Эрчим хүч ХХК-ийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна гэж үзлээ.

Санхүү нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд гүйцэтгэх захирлын 2023 оны А/124 дүгээр тушаалаар баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж ажилласан байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хөвсгөл Эрчим хүч ХХК-ийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дугаар тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,848.2 сая төгрөгөөр буюу 5.9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	өөрчлөлт
Мөнгөн хөрөнгө	81,224.80	268,769.21	187,544.41
Авлага	688,515.65	937,493.26	248,977.61
Бараа материал	488,001.35	595,363.85	107,362.50
Биет хөрөнгө	29,219,578.87	30,529,114.35	1,309,535.48
Биет бус хөрөнгө	656,270.83	651,056.54	-5,214.30
Нийт хөрөнгө	31,133,591.50	32,981,797.21	1,848,205.71
Богино хугацаат өр төлбөрийн дүн	1,861,554.47	2,007,833.20	146,278.73
Урт хугацаат өр төлбөрийн дүн	871,670.46	680,338.26	-191,332.20
Эздийн өмчийн дүн	28,400,366.56	30,293,625.74	1,893,259.18
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	31,133,591.50	32,981,797.21	1,848,205.71

Санхүүгийн тайлангийн тодруулгыг мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, авлага, бараа материал, өр төлбөр гэсэн данс бүрээр холбогдох журам, зааврын дагуу бэлтгэсэн байна. Тайланд онд үндсэн хөрөнгө, бараа материал дансанд дараах хөдөлгөөн хийгдсэн байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 268.7 сая болж 187.5 сая төгрөгөөр өссөн нь тарифын үнэ өссөн, бусад орлого нэмэгдсэнтэй холбоотой байна.
- Авлага дансны үлдэгдэл 937.4 сая төгрөг болж 248.9 сая төгрөгөөр нэмэгдэхэд нөлөө үзүүлсэн гол хүчин зүйл нь тайлант онд 1 квт цахилгаан эрчим хүчний үнэ тарифын өөрчлөлтөөс шалтгаалсан байна.
 - Айл өрхийн цахилгаан эрчим хүчний авлага 204.2 сая төгрөгөөр өссөн байна.
 - Хогны авлага 17.9 сая төгрөгөөр өссөн байна.
 - Телевизийн хураамжийн авлага 2.7 сая төгрөгөөр өссөн байна.
 - Цахилгаан эрчим хүчний тарифын хөнгөлөлтийн авлага 95.3 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.
 - Татвар, НДШ-ийн авлага 24.9 сая төгрөгөөр өссөн нь НӨАТ-ийн авлага нэмэгдсэнтэй холбоотой байна.
- Бараа материал дансны үлдэгдэл 595.4 сая төгрөг болж 107.4 сая төгрөгөөр нэмэгдэхэд нөлөө үзүүлсэн гол хүчин зүйл нь тайлант онд 1,708.0 сая төгрөгийн бараа материал худалдан авч, 1,595.9 сая төгрөгийн материал зарцуулсан ба 4.7 сая төгрөгийн бараа материалыг байгууллагын даргын тушаалаар акталж, Могойн голын 35 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын ПС70 элемент солих ажлын материал 21.6 сая төгрөг, АТП-46 дэд станцын задгай холбогдсон 216 айл өрхийн тоолуур нэгтгэлийн ажлын материал 28.1 сая төгрөг, 110/35/610кВ-ын Мөрөн дэд станцаас 6кВ-ын хаалттай хуваарилах байгууламжийн

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	81,224,795.97	268,769,209.22
1.1.2	Дансны авлага	687,232,730.67	911,305,212.97
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	1,282,918.32	26,188,043.99
1.1.6	Бараа материал	488,001,348.38	595,363,851.77
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	1,257,741,793.34	1,801,626,317.95
1.2.1	Үндсэн хөрөнгө	29,219,578,870.80	30,529,114,353.27
1.2.2	Биет бус хөрөнгө	656,270,832.35	651,056,535.48
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	29,875,849,703.15	31,180,170,888.75
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	31,133,591,496.49	32,981,797,206.70
2.1.1.1	Дансны өглөг	1,775,665,355.31	1,938,330,951.79
2.1.1.3	Татварын өр	42,895,240.33	42,469,612.81
2.1.1.4	НДШ-ийн өглөг	0.00	114,785.72
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	42,993,875.67	26,917,850.05
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	1,861,554,471.31	2,007,833,200.37
2.1.2.1	Урт хугацаат зээл	871,670,464.46	680,338,264.46
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	871,670,464.46	680,338,264.46
2.2	Өр төлбөрийн нийт дүн	2,733,224,935.77	2,688,171,464.83
2.3.1	Төрийн өмч	16,800,000,000.00	16,800,000,000.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	7,831,501,384.55	7,831,501,384.55
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	8,732,310,253.97	9,996,667,789.93
2.3.9	Хуримтлагдсан ашиг	-4,963,445,077.80	-4,334,543,432.61
2.3.11	Эздийн өмчийн дүн	28,400,366,560.72	30,293,625,741.87
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	31,133,591,496.49	32,981,797,206.70

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн /төгрөгөөр/
1	Борлуулалтын орлого (цэвэр)	17,279,239,414.73	20,963,830,758.73
2	Борлуулалтын өртөг	15,443,954,754.64	18,155,346,549.26
3	Нийт ашиг (алдагдал)	1,835,284,660.09	2,808,484,209.47
4	Хүүгийн орлого	404,299.10	875,638.82
5	Бусад орлого	417,660,908.89	419,272,103.78
6	Борлуулалт, маркетингийн зардал	1,775,603,783.45	2,384,294,494.82
7	Ерөнхий ба удирдлагын зардал	175,895,704.21	208,772,401.73
8	Бусад зардал	438,617,943.24	231,786,798.95
9	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-21,850,302.12	0.00
10	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	-158,617,864.94	403,778,256.57
11	Орлогын татварын зардал	0.00	40,290,261.78
12	Татварын дараах ашиг (алдагдал)	-158,617,864.94	363,487,994.79
13	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-158,617,864.94	363,487,994.79
14	Орлогын нийт дүн	-158,617,864.94	363,487,994.79

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	16,800,000,000.00	7,831,501,384.55	8,317,866,421.53	-4,799,824,529.20	28,149,543,276.88
3	Залруулсан үлдэгдэл	16,800,000,000.00	7,831,501,384.55	8,317,866,421.53	-4,799,824,529.20	28,149,543,276.88
5	Өмчид гаргасан өөрчлөлт	0.00	0.00	347,958,131.59	0.00	347,958,131.59
7	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	-163,620,548.60	-163,620,548.60
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	7,831,501,384.55	0.00	0.00	7,831,501,384.55
9	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	16,800,000,000.00	7,831,501,384.55	8,732,310,253.97	-4,963,445,077.80	28,400,366,560.72
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	265,413,650.40	265,413,650.40
11	Залруулсан үлдэгдэл	16,800,000,000.00	7,831,501,384.55	8,732,310,253.97	-4,698,031,427.40	28,665,780,211.12
13	Өмчид гаргасан өөрчлөлт	0.00	0.00	1,264,357,535.96	0.00	1,264,357,535.96
15	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	363,487,994.79	363,487,994.79
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	7,831,501,384.55	0.00	0.00	7,831,501,384.55
17	2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	16,800,000,000.00	7,831,501,384.55	9,986,667,789.93	-4,334,543,432.61	30,293,625,741.87

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Тайлант үеийн дүн	Өссөн дүн
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	17,106,455,978.43	17,106,455,978.43
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	17,062,366,504.08	17,062,366,504.08
1.1.6	Бусад мөнгөн орлого	44,089,474.35	44,089,474.35
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-16,641,736,367.64	16,641,736,367.64
1.2.1	Ажиллагчдад төлсөн	-2,139,860,846.17	-2,139,860,846.17
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	-944,135,609.00	-944,135,609.00
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	-1,262,552,263.32	-1,262,552,263.32
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	-4,638,397.96	-4,638,397.96
1.2.5	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	-10,916,959,643.47	10,916,959,643.47
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	-5,882,719.44	-5,882,719.44
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	-938,989,794.95	-938,989,794.95
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	-9,941,381.82	-9,941,381.82
1.2.9	Бусад мөнгөн зарлага	-418,775,711.51	-418,775,711.51
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	464,719,610.79	464,719,610.79
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	875,638.82	875,638.82
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	875,638.82	875,638.82
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-86,718,636.36	-86,718,636.36
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-86,718,636.36	-86,718,636.36
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-85,842,997.54	-85,842,997.54
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-191,332,200.00	-191,332,200.00
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	-191,332,200.00	-191,332,200.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-191,332,200.00	-191,332,200.00
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	187,544,413.25	187,544,413.25
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	81,224,795.97	81,224,795.97
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	268,769,209.22	268,769,209.22

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Зардлын төрөл	Тайлант оны		
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
		1	2	1-2
1	Борлуулалтын орлого	14,413,600.0	14,296,746.1	116,853.9
2	Түгээх үйлчилгээний орлого	6,667,084.7	6,667,084.7	-
3	Бусад орлого	400,000.0	420,147.743	(20,147.7)
НИЙТ ОРЛОГО		21,480,684.7	21,383,978.5	96,706.2
1	Шатахууны зардал	151,620.2	141,579.1	10,041.1
2	Тээврийн зардал	4,704.5	5,295.5	(591.0)
3	Сэлбэг хэрэгсэл	123,830.7	121,191.1	2,639.6
4	Урсгал засвар	170,979.4	126,137.7	44,841.7
5	Материал, хангамжийн материал	4,305.5	4,700.5	(395.0)
6	Үндсэн ба нэмэгдэл цалин, урамшуулал	3,407,324.2	3,406,137.510	1,186.7
7	Байгууллагаас төлөх ЭМ, НДШ	523,657.2	497,377.610	26,279.6
8	Ашиглалтын зардал-Цахилгаан	67,998.5	63,995.47	4,003.0
9	Ашиглалтын зардал-Дулаан	60,298.8	60,457.11	(158.3)
10	Ашиглалтын зардал-Ус	4,550.0	3,171.21	1,378.8
11	Албан томилолтын зардал	158,261.2	158,114.6	146.6
12	Конторын хангамжийн зардал	11,861.2	21,253.8	(9,392.6)
13	Харилцаа холбооны зардал	11,756.3	9,852.2	1,904.1

14	Харуул хамгаалалтын зардал	-	-	-
15	Хөдөлмөр хамгааллын зардал	184,521.4	168,807.6	15,713.8
16	Даатгалын зардал	10,457.2	9,941.4	515.8
17	Галын аюулаас хамгаалах зардал	1,076.2	1,076.2	-
18	Гүйцэтгэх удирдлагын зардал	57,240.0	63,921.5	(6,681.5)
19	Төлөөлөн удирдах зөвлөлийн зардал	57,015.2	85,225.6	(28,210.4)
20	Борлуулалт, маркетингийн зардал	41,922.0	45,505.3	(3,583.3)
21	Зохицуулалтын үйлчилгээний хөлс	20,000.0	20,000.0	-
22	Гадны үйлчилгээний хөлс	78,014.6	75,618.1	2,396.5
23	Аваарын нөөцийн зардал	19,863.5	-	19,863.5
24	ХАЦ-ын өглөг	557,824.7	-	557,824.7
25	Сургалтын зардал	23,840.4	23,090.8	749.6
		5,752,922.9	5,112,449.9	640,473.0
26	Элэгдлийн зардал	1,637,669.3	1,662,497.8	(24,828.5)
	Үүнээс: Ерөнхий хэрэглээний үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал	40,374.0	51,237.5	(10,863.5)
	Үйлдвэрлэлийн зориулалттай үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал	1,597,295.3	1,611,260.3	(13,965.0)
27	Орлогын албан татвараас бусад татвар	15,035.2	10,181.5	4,853.7
	Үүнээс: Үл хөдлөх хөрөнгийн татвар	8,273.6	5,395.5	2,878.1
	АТӨЯХ-ийн албан татвар	999.1	976.6	22.5
	Газрын төлбөр	5,762.5	3,809.4	1,953.1
	Бусад татвар хураамж	-	-	-
28	Хүүгийн зардал-Урт хугацаат зээл	197,695.2	5,882.7	191,812.5
29	Бусад	-	-	-
30	Үйл ажиллагааны бус бусад зардал	146,185.7	118,170.5	28,015.1
31	Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз	-	-	-
32	Ажиллагсдын нийгмийн зардал	285,428.0	273,477.4	11,950.6
	Хөрөнгө оруулалтын өгөөжөөр нөхөгдөх зардлын дүн	629,308.9	397,530.7	231,778.2
33	Валютын ханшны алдагдал	-	-	-
	Үйл ажиллагааны зардлын дүн	8,034,936.3	7,182,659.8	852,276.5
34	Худалдаж авсан ЦЭХ-ний төлбөр	13,673,000.0	13,683,924.2	(10,924.2)
	Нийт Үндсэн ҮА-ны зардал	21,707,936.3	20,866,584.0	841,352.3
	Үндсэн бус үйл ажиллагааны зардлын дүн	135,248.4	113,616.3	21,632.1
	НИЙТ ЗАРДАЛ /37+40+43/	21,843,184.7	20,980,200.2	862,984.5
38	Нийт ашиг/алдагдал /48-44/	(362,500.0)	403,778.3	(766,278.3)

3. Аудитын тайлан

3.1 Компани, түүний үйл ажиллагаа

Хөвсгөл Эрчим хүч ХХК нь цахилгаан эрчим хүчийг найдвартай, тасралтгүйгээр хэрэглэгчдэд түгээн борлуулж, аваар осолгүй, эдийн засгийн хувьд үр өгөөжтэй, хэрэглэгчдэд үйлчилгээ үзүүлэхдээ цаг үеийн шаардлага, эрчим хүчний техник технологийн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн боловсруулсан зөв бодлогыг хэрэгжүүлж, хэрэглэгчдийнхээ хэрэгцээ шаардлагад нийцсэн шуурхай ухаалаг үйлчилгээг үзүүлэх, техникийн шинэчлэлийг үе шаттай хийх замаар түгээх сүлжээний техникийн алдагдал, арилжааны алдагдлыг бууруулан ажиллах зорилготой үйл ажиллагаа явуулж байна.

3.2 Компанийн гадаад дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчны талаар:

Компанийн эрх барих дээд байгууллага нь Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, хурлын чөлөөт цагт эрх барих дээд байгууллага нь компанийн Төлөөлөн Удирдах зөвлөл байхаар компанийн дүрэмд тусгасан байна.

Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 5 дугаар сарын 02-ний өдрийн 21 дүгээр тогтоолоор компанийн Төлөөлөн Удирдах зөвлөл төрийг төлөөлөх 3 гишүүн, хараат бус 6 гишүүний бүрэлдэхүүнтэй томилогдсон Төлөөлөн удирдах зөвлөл ажилласан байна. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нь тайлант онд 8 удаа хуралдаж 23 шийдвэрийг гаргасан байна. Үүнээс компанийн бүтэц зохион байгуулалттай холбоотой 1 тогтоол, бизнес төлөвлөгөө, техник зохион байгуулалтын арга хэмжээний зардалтай холбоотой 11 тогтоолыг хэлэлцэж баталсан байна.

Хөвсгөл эрчим хүч ХХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн хуралдааны III/22 дугаар тогтоолоор бүрэлдэхүүнийг төрийг төлөөлөх 3 гишүүн, хараат бус 6 гишүүнтэйгээр өөрчлөн баталсан байна.

2024 оны санхүүгийн тайлангийн аудитын хугацаанд компанийн гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар солигдсон байна.

Хууль эрх зүйн орчны талаар:

Тус байгууллага нь Компанийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Эрчим хүчний тухай хууль, Эрчим хүч хэмнэлтийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, нийгмийн даатгалын шимтгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон бусад хууль тогтоомж журам зааврын мөрдөн ажилласан байна. Тайлант онд дараах хууль тогтоомжууд шинээр батлагдсан байна. Үүнд:

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /2024.01.01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн/
- Нийгмийн даатгалын багц хууль /2024.01.01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн/
- Эрчим хүчний зохицуулах хорооны 2024 оны 632 дугаар тогтоол "Тариф батлах тухай"
- Эрчим хүчний зохицуулах хорооны 2024 оны 636 дугаар тогтоол "Тариф батлах тухай"

Байгууллагын дотоод хяналтын талаар: Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж үзлээ.

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 11 дүгээр тогтоолоор Дотоод аудитын албыг татан буулгаж, дотоод хяналтын ажилтантай байхаар бүтцийн өөрчлөлтийг хийсэн байна.

Тус байгууллагын дотоод хяналтын ажилтны ажиллах журмыг Хөвсгөл Эрчим Хүч ХХК-ийн гүйцэтгэх захирлын 2023 оны А/64 дүгээр тушаалаар шинэчлэн баталсан байна.

Дотоод хяналтын албаны ажилтан нь тайлант онд хийх хяналт, шалгалтын ажлын төлөвлөгөөг боловсруулж эрх бүхий ажилтнаар батлуулаагүй, хийж хэрэгжүүлсэн ажлын тайлан байхгүй байна.

Энэ нь Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ын 3.4. *Дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтан нь тухайн аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны онцлог, үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэл, хэмжээ, зохион байгуулалтын бүтэц, харьяалагдах нэгж, объектын тоог харгалзан тухайн жилд хийх хяналт шалгалтын ажлын тусгайлсан төлөвлөгөөг боловсруулан эрх бүхий албан тушаалтнаар батлуулан мөрдөж ажиллана.*, 4.1. *Дотоод хяналт шалгалтыг дараах чиглэлээр зохион байгуулна:* гэсэнтэй тус тус нийцэхгүй, "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

Тайлант онд аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт аудитын алба болон Татварын газраас байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

ажлын шинэчлэлийн материал 30.2 сая төгрөг, АТП-46,ХТП-26 дэд станцуудын 0.4 кВ ЦДАШ болон 10кВ-ын Бүрэнтогтох,Түнэл гаргалгааны ЦДАШ -уудын газардуулгын материал 12.7 сая төгрөг нийт 92.6 сая төгрөгийн материал данс бүртгэлд үлдсэнтэй холбоотой байна.

4. Биет хөрөнгө дансанд аймгийн ИТХ-ын даргын 2024 оны А/98 дугаар захирамжаар Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлж бий болсон 1,171.4 сая төгрөгийн цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд өртөө, аймгийн ИТХ-ын даргын 2024 оны А/119, А/145 дугаар захирамжаар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон 92.9 сая төгрөгийн гадна цахилгаан /0.4 кв-ын кабель шугам/ болон цахилгаан КТПН10/0.4 кв 100 кВ нийт 1,264.3 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авсан байна.
5. Худалдан авсан цахилгаан эрчим хүчний өглөг 569.8 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.
6. Урт хугацаат өр төлбөрийн дансанд бүртгэлтэй Сангийн яам, Хөвсгөл Эрчим хүч ХХК-ийн хооронд байгуулсан дамжуулан зээлдүүлэх зээлээс тайлант онд 191.3 сая төгрөгийг төлсөн байна.
7. Эздийн өмчийн бусад хэсэгт аймгийн ИТХ-ын шийдвэрээр шилжиж ирсэн 1,264.3 сая төгрөгийн хөрөнгө бүртгэсэн байна.

Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Өр төлбөрийн дэлгэрэнгүй журналыг хянан үзэхэд Мэйжүрмэнт ХХК-д өгөх өр төлбөрийн эхний үлдэгдэл хасах 5.8 сая төгрөг байх ба энэ дүнгээр нийт өрийг бууруулж тайланд тусгасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4.үнэн зөв байх; гэсэн заалттай нийцэхгүй, "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэлт:

Тус зөрчилд зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Хөвсгөл Эрчим хүч ХХК нь үйлдвэрлэл, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Хөвсгөл Эрчим Хүч ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 3 дугаар сарын 01-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, техник зохион байгуулалтын арга хэмжээний зардлыг баталсан байна.Тайлант оны нийт орлогыг 17,722.2 сая төгрөгөөр, нийт зардлыг 18,982.2 сая төгрөгөөр, 1.0 сая төгрөгийн алдагдалтай ажиллахаар анх баталсан байна.

Тайлант онд Хөвсгөл эрчим хүч ХХК-ийн ТУЗ-ийн 2024 оны 04 сарын 23-ны өдрийн 07 дугаар тогтоолоор БОШХ-ийн зардал болон үйл ажиллагааны бус зардлын төлөвлөгөөнд , 2024 оны 06 сарын 27-ны 09 дугаар тогтоолоор хөрөнгө оруулалт их засвар ТЗБАХ-ын ажлын төлөвлөгөөнд , 2024 оны 10 сарын 31-ний өдрийн 15 дугаар тогтоолоор 2024 оны бизнес төлөвлөгөө болон ТЗБАХ-ийн зардалд, 2024 оны 12 сарын 16-ны өдрийн 22 дугаар тогтоолоор 2024 оны үйл ажиллагаа бизнес төлөвлөгөөнд нийт 4 удаа тодотгол оруулж нийт орлогыг 21,480.9 сая төгрөгөөр, нийт зардлыг 21,843.4 сая төгрөгөөр, 362,5 сая төгрөгийн алдагдалтай ажиллахаар тогтоосон байна. Мөн их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний зардалд 1,275.1 сая төгрөгөөр төлөвлөж баталсан байна.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

/мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Зорилтот түвшин	Гүйцэтгэл	Өөрчлөлт	Биелэлт
1	Түгээлтэд авсан цахилгаан	мян.кВтц	88,619.7	88,660.4	40.7	100.0
2	Цахилгаан түгээлтийн алдагдал	мян.кВтц	14,462.8	14,655.7	192.9	101.3
		Хувь	16.32%	16.50%	0.0	101.1
3	Борлуулсан цахилгаан	мян.кВтц	74,157.0	74,004.8	-152.2	99.8
4	Нийт орлого	сая.төгрөг	21,480.9	21,384.0	-96.9	99.5
	Борлуулалтын орлого	сая.төгрөг	14,413.7	14,296.7	-117.0	99.2

	Түгээх үйлчилгээний орлого	сая.төгрөг	6,667.2	6,667.1	-0.1	100.0
	Үйл ажиллагааны бусад орлого	сая.төгрөг	400.0	420.1	20.1	105.0
5	Нийт зардал	сая.төгрөг	21,843.4	20,980.2	-863.2	96.0
	Үйл ажиллагааны зардал	сая.төгрөг	8,035.0	7,182.7	-852.3	89.4
	Худалдан авсан цахилгаан эрчим хүчний өртөг	сая.төгрөг	13,673.0	13,683.9	10.9	100.1
	Үйл ажиллагааны бусад зардал	сая.төгрөг	135.4	113.6	-21.8	83.9
6	Нийт ашиг алдагдал	сая.төгрөг	-362.5	403.8	766.3	-111.4

Гүйцэтгэлээр 21,384.0 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 20,980.2 сая төгрөгийн зардал гарган, 403.8 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 21,384.0 сая төгрөг болж төлөвлөснөөс 96.9 сая төгрөг буюу 0.5 хувиар тасарсан нь түгээн борлуулах цахилгаан эрчим хүчний төлөвлөгөө 152.2 мян.кВтц-аар буюу 0.2 хувиар дутуу борлуулснаас шалтгаалсан байна.

Нийт зардлын гүйцэтгэл 20,980.2 сая төгрөг болж, төлөвлөснөөс 863.2 сая төгрөгөөр дутуу буюу 96.0 хувийн гүйцэтгэлтэй байна. Энэ нь тээвэр шатахууны зардал 10.0 сая төгрөг, урсгал засвар 64.7 сая төгрөг, цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 27.4 сая төгрөг, хөдөлмөр хамгааллын хэрэгсэл 15.7 сая төгрөгөөр хэмнэгдсэн нь голлох нөлөөг үзүүлсэн байна.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний зардлыг 1,275.1 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 1,168.4 сая төгрөгийг 23 нэр төрлийн ажлыг өөрийн эх үүсвэрээр санхүүжүүлсэн байна. Үүнээс их засвартай холбоотой 8 ажилд 452.8 сая төгрөг, хөрөнгө оруулалттай холбоотой 7 ажилд 511.6 сая төгрөг, техник зохион байгуулалтын 8 ажилд 230.9 сая төгрөгийг зарцуулсан байна.

Тайлант онд ашиг 403.8 сая төгрөг болж, төлөвлөснөөс 766.2 сая төгрөгөөр илүү байгаа нь үйл ажиллагааны зардлын хэмнэлттэй холбоотой байна.

Тайлант онд зарцуулалт, тайлагналтай холбоотой дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Тайлант онд албан хаагчдад олгосон албан томилолтыг хянаж үзэхэд албан томилолтоор ажилласан албан хаагчдын дансанд тус бүрд биш нийт дүнгээр нь нэг албан хаагчийн дансанд шилжүүлж байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4. "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажуулаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэсэн заалтыг зөрчсөн ба тохиолдсон байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэлт:

Тус зөрчилд зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

2. Шатахууны зарцуулалтад түүвэрлэн хяналт хэрэгжүүлэхэд жолоочийн тооцооны хуудсыг нягтлан бодогчоор бодуулж, холбогдох албан хаагчаар баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.5 "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэлт:

Тус зөрчилд зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

1. Анхан шатны баримтын бүрдэлгүй 1.2 сая төгрөгийн томилолтын зардал санхүүжүүлсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасныг зөрчсөн, "тохиолдсон байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэлт:

Тус зөрчилд **төлбөрийн акт** тогтоохоор шийдвэрлэлээ.

- Байгууллагын 2024 оны 12 сард хийсэн гүйлгээнээс хяналт хэрэгжүүлэхэд Би Би Ай Ди ХХК-аас худалдан авсан 9.3 сая төгрөгийн үнэтэй трансформаторыг биетээр хүлээн аваагүй байхад данс бүртгэлд бүртгэж тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4.үнэн зөв байх, 20.1.2-т "нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон хууль тогтоомжид харшилсан шийдвэрийг биелүүлэхээс татгалзах", 20 дугаар зүйлийн 20.1.4-т "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэж заасныг тус тус зөрчсөн, Оршин байх, Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэлт: Тус зөрчилд **төлбөрийн акт** тогтоохоор шийдвэрлэлээ.

Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6 Ерөнхий чиглэлийн хүрээнд авсан судалгааны үр дүнгийн талаар:

Хөвсгөл эрчим хүч ХХК-ийн 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар тус компанид хамааралтай дараах 3 чиглэлээр судалгаа авч, үр дүнг тайланд тусгалаа.

- Хөвсгөл эрчим хүч ХХК нь ахмадын сан байгуулж, жилийн төсөвтөө төлөвлөж батлуулаагүй байна. Энэ нь Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7 "Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах бөгөөд Ахмадын сан байгуулан ажиллуулах журмыг Засгийн газар батална", Засгийн газрын 2024 оны 243 дугаар тогтоолоор баталсан "Ахмадын сан байгуулан ажиллуулах журам"-тай нийцэхгүй байна.
Аудитын шийдвэрлэлт: Албан шаардлага хүргүүлэх
- Хөвсгөл эрчим хүч ХХК нь тайлант онд бараа ажил үйлчилгээ худалдан авах төлөвлөгөө, тайланг Tender.gov.mn цахим системд нийтэлж, ажилласан байна. Худалдан авах ажиллагаатай холбоотой зөрчлийг тайлангийн 4.4.2-д харуулав.
- Хөвсгөл эрчим хүч ХХК-ийн бүтэц, орон тоог Хөвсгөл эрчим хүч ХХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 04 сарын 23-ны өдрийн 05 дугаар тогтоолоор үндсэн ажилтан 118, гэрээт ажмлан 8, нийт 122 орон тоотой байхаар баталсан байна. Тайлант онд орон тоо хэтрүүлэн ажиллаагүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Хөвсгөл Эрчим Хүч ХХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх компани, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Л.Мөнх-Оргил гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Б.Давааням, аудитын менежер Б.Тэгшдэлгэр, дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Хөвсгөл Эрчим хүч ХХК-ийн 2024 оны санхүүгийн тайланг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 02 дугаар сарын 11-ний 1/33 албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 17,834.0 сая төгрөгөөс 2 хувиар буюу 356.7 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 буюу 285.3 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага Тэргүүн дэд, дэд, орлогч дарга, тээврийн хэрэгсэл, албан тасалгаа, дүрэмт хувцас, албан томилолт, нэг удаагийн мөнгөн тэтгэмж, бусад хангамж, цахим худалдан авалт, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хориглосон зарим асуудал, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт 32 асуудлаар хяналтын сорилыг хэрэгжүүллээ. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор дараах зөрчил илэрсэн болно.

1. Тайланд оны зардлыг хянахад 1.7 сая төгрөгөөр согтууруулах ундаа худалдан авсан байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.7-д *"байгууллагын төсвөөр согтууруулах ундаа худалдан авах"* гэж заасныг зөрчсөн, *"нийцсэн бөгөөд зохистой байх"* батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэлт:

Төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэлээ.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Байгууллагын 2024 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллагын шилэн дансны цахим хуудасны мэдээллээс дараах мэдээллийг түүвэрлэн хяналт хэрэгжүүллээ. Үүнд:

- Теңдэрт шалгарсан болон шалгараагүй талаарх товч мэдээлэл
- Цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ
- Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн мэдээлэл

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

Тайланд онд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгийн зарлагын 145 гүйлгээний 1,600.8 сая төгрөгийн мэдээллийг мэдээлээгүй. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4. Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ: 6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 17,834.0 сая төгрөгөөс 2 хувиар буюу 356.7 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 буюу 285.3 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага Тэргүүн дэд, дэд, орлогч дарга, тээврийн хэрэгсэл, албан тасалгаа, дүрэмт хувцас, албан томилолт, нэг удаагийн мөнгөн тэтгэмж, бусад хангамж, цахим худалдан авалт, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хориглосон зарим асуудал, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт 32 асуудлаар хяналтын сорилыг хэрэгжүүллээ. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор дараах зөрчил илэрсэн болно.

1. Тайланд оны зардлыг хянахад 1.7 сая төгрөгөөр согтууруулах ундаа худалдан авсан байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.7-д *"байгууллагын төсвөөр согтууруулах ундаа худалдан авах"* гэж заасныг зөрчсөн, *"нийцсэн бөгөөд зохистой байх"* батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэлт:

Төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэлээ.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Байгууллагын 2024 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллагын шилэн дансны цахим хуудасны мэдээллээс дараах мэдээллийг түүвэрлэн хяналт хэрэгжүүллээ. Үүнд:

- Теңдэрт шалгарсан болон шалгараагүй талаарх товч мэдээлэл
- Цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ
- Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн мэдээлэл

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

Тайланд онд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгийн зарлагын 145 гүйлгээний 1,600.8 сая төгрөгийн мэдээллийг мэдээлээгүй. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4. Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ: 6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын

мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр, заалттай нийцэхгүй байгаа ба "нийцсэн бөгөөд зохистой" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэлт:

Зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Аудитаар хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянаж үзэхэд дарах зөрчлүүд илэрлээ.

Компанийн Төлөөлөн Удирдах зөвлөлийн тогтоол шийдвэртэй холбоотой дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

1. Тайлант онд Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргад 13.2 сая төгрөгийн тэтгэмж илүү олгосон нь хууль эрх зүйн үндэслэлгүй, эрүүл мэндийн шалтгаантай ажлаас чөлөөлөгдсөн гэх боловч, Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын шийдвэргүй нотлох баримт хангалтгүй байна. Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.1.3 дах заалтыг зөрчсөн ба нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэлт: Тус зөрчилд **төлбөрийн акт** тогтоохоор шийдвэрлэлээ.

2. Тайлант онд тус компанийн зорилтот түвшнийг 4 удаа тодотгож баталсан ба энэ нь санхүүгийн үйл ажиллагааг тогтворгүй болгох, санхүүгийн сахилга батыг алдагдуулах эрсдэлтэй ба ТУЗ-ийн Аудитын хороо нь холбогдох хяналтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Энэ нь компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.4. "Энэ хуулийн 81.2-т заасан аудитын хорооны дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн байх бөгөөд уг хороо нь дараах чиглэлээр дүгнэлт гаргаж, төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулна" заалттай нийцэхгүй, Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэлт:

Тус зөрчилд **зөвлөмж** хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэлийн талаар:

Хөвсгөл эрчим хүч ХХК нь 2024 онд Хөвсгөл Эрчим Хүч ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн 02 дугаар тогтоолоор нийт 1,601.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 32 бараа, ажил, үйлчилгээг худалдан авахаар анх төлөвлөн баталсан байна.

Тайлант онд Хөвсгөл Эрчим Хүч ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолоор Хөвсгөл эрчим хүч ХХК-ийн 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, техник зохион байгуулалтын арга хэмжээний зардалд 4 удаагийн тодотгол хийж, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 4 удаа өөрчлөлт орж нийт 1,834.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 44 бараа, ажил, үйлчилгээг худалдан авахаар баталсан байна.

Төсвийн тухай хуулийн 54.5.3-д заасны дагуу худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэл гаргаж тайлагнасан байна.

Хүснэгт 3. Худалдан авах ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл

№	Худалдан авах ажиллагаанд мөрдсөн журам, арга	Төлөвлөгөө		Гүйцэтгэл		Тендерийн хэмнэлт
		Бараа ажил үйлчилгээний тоо	Төсөвт өртөг	Бараа ажил үйлчилгээний тоо	Гэрээ байгуулсан дүн	
1	Нээлттэй тендер шалгаруулалт	2	345,800.0	2	335,785.0	10,015.0
2	Харьцуулалтын арга	19	1,187,498.8	19	1,068,808.9	118,689.9
3	Шууд худалдан авалт	23	301,559.7	22	298,756.3	2,803.4
ДҮН		44	1,834,858.5	43	1,703,350.2	131,508.3

/мянган төгрөг/

2024 онд 2 нэр төрлийн 345.8 сая төгрөгийн төсөвтэй нээлттэй тендер шалгаруулалт, 19 нэр төрлийн 1,187.4 сая төгрөгийн төсөвтэй харьцуулалтын тендер, 22 нэр төрлийн 300.9 сая төгрөгийн төсөвтэй шууд худалдан авалтуудыг зохион байгуулж ажилласан байна. Төлөвлөгөөнд тусгагдсанаас 0.7 сая төгрөгийн төсөвтэй галын хорны худалдан авалт хийгдээгүй байна. Нийт 1,834.8 сая төгрөгийн төсөвтэй тендер шалгаруулалтыг зохион байгуулж 1,703.4 сая төгрөгийн гэрээ байгуулж 131.5 сая төгрөгийн тендерийн хэмнэлт гарсан байна.

Тайлант оны худалдан авах ажиллагаанаас түүвэрлэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцсэн эсэхэд хяналт хийхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Илрүүлэлт:

Хөвсгөл эрчим хүч ХХК-ны 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг хянахад тайлант онд ТУЗ-аас худалдан авах ажиллагаанд 4 удаа тодотгол хийсэн ба тус худалдан авахаар төлөвлөсөн зарим төсөл арга хэмжээний хүрээнд зохион байгуулах ажлуудыг хууль, журамд нийцүүлээгүй, зах зээлийн үнээс өндрөөр төлөвлөж худалдан авалт хийсэн, худалдан авах ажиллагаа зохион байгуулж гэрээ байгуулаагүй байхад худалдан авалт хийсэн зэрэг зөрчилтэй асуудал илэрч байна.

Өгсөн албан шаардлага:

Худалдан авах ажиллагааны зөрчлийг арилгаж, дотоод хяналтыг эрчимжүүлэх

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Хөвсгөл Эрчим хүч ХХК-ийн 2024 оны III улирлын санхүүгийн тайланд завсрын аудит хийж нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 218.2 сая төгрөгийн 2 зөвлөмж хүргүүлсэн байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	218,183.6	2	218,183.6	100
Нийт дүн	2	218,183.6	2	218,183.6	100

Завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн 2 зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт 85.3 хувьтай байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	9	33,284.9	8	26,577.9	89
Албан шаардлага	6	507,052.9	6	507,052.9	100
Зөвлөмж	9	0	6	0	67
Нийт дүн	24	540,337.8	20	536,809.3	85.3

Өмнөх аудитаар тогтоосон 33.3 сая төгрөгийн төлбөрийн актаас 26.6 сая төгрөгийн актыг бүрэн барагдуулсан байна. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хянаж үзэхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Санхүүгийн болон татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүгийн тайланг бэлтгэж, үр дүнг санхүүгийн тайланд тусгаж ажиллахтай холбоотой болон компанийн хамтын гэрээг хууль журамд нийцүүлэн өөрчлөх зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэлт:

Тус зөрчилд зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

2. Хөвсгөл аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн, 2021 оны 06 сарын 14-ний өдрийн 155/ШШ2021/00638 дугаар тушаалаар В.Чулуунд 3.5 сая төгрөгийг олгосон ба тус мөнгийг буруутай албан тушаалтнаар төлүүлээгүй байна. Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1 "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай этгээдээр буцааж төлүүлнэ." гэсэн заалттай нийцэхгүй байна

Шийдвэрлэлт:

Тус зөрчилд зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт нийцлийн аудитаар Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудлыг нарийвчлан хянах нь зүйтэй байна.

5. Аудитын илрүүлэлт

5.1 Аудитаар нийт 5.8 сая төгрөгийн алдааг илрүүлсэн ба аудитын хугацаанд залруулагдаагүй. Үүнд:

1. Өр төлбөрийн дэлгэрэнгүй журналыг хянан үзэхэд Мэйжүрмэнт ХХК-д өгөх өр төлбөрийн эхний үлдэгдэл хасах 5.8 сая төгрөг байх ба энэ дүнгээр нийт өрийг бууруулж тайланд тусгасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4.үнэн зөв байх; гэсэн заалттай нийцэхгүй, "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 1,615.8 сая төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 25.3 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 3 албан шаардлага хүргүүлж, 1,604.3 сая төгрөгийн зөрчилд 6 зөвлөмж өгсөн.

5.2 Төлбөрийн акт

Аудитаар дараах зөрчлүүдэд төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэлээ. Үүнд:

1. Анхан шатны баримтын бүрдэлгүй 1.2 сая төгрөгийн томилолтын зардал санхүүжүүлсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасныг зөрчсөн, Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
2. Байгууллагын төсвөөс 1.7 сая төгрөгөөр согтууруулах ундаа худалдан авсан байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.7-д "байгууллагын төсвөөр согтууруулах ундаа худалдан авах" гэж заасныг зөрчсөн, "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.
3. Байгууллагын 2024 оны 12 сард хийсэн гүйлгээнээс хяналт хэрэгжүүлэхэд Би Би Ай Ди ХХК-аас худалдан авсан 9.3 сая төгрөгийн үнэтэй трансформаторыг биетээр хүлээн аваагүй байхад данс бүртгэлд бүртгэж тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4.үнэн зөв байх, 20.1.2-т "нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон хууль тогтоомжид харшилсан шийдвэрийг биелүүлэхээс татгалзах", 20 дугаар зүйлийн 20.1.4-т "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэж заасныг тус тус зөрчсөн, Оршин байх, Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

5.3 Албан шаардлага

1. Аудитаар дараах зөрчлүүдэд зөрчил таслан зогсоох албан шаардлага хүргүүлээ. Үүнд:Хөвсгөл эрчим хүч ХХК-ны 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг хянахад тайлант онд ТУЗ-аас худалдан авах ажиллагаанд 4 удаа тодотгол хийсэн ба тус худалдан авахаар төлөвлөсөн зарим төсөл арга хэмжээний хүрээнд зохион

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

байгуулах ажлуудыг хууль, журамд нийцүүлээгүй, зах зээлийн үнээс өндрөөр төлөвлөж худалдан авалт хийсэн, худалдан авах ажиллагаа зохион байгуулж гэрээ байгуулаагүй байхад худалдан авалт хийсэн зэрэг зөрчилтэй асуудал илэрч байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно", Засгийн газрын 2024 оны 01 дүгээр тогтоолоор баталсан босго үнийг баримтлаагүй, "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2. Хөвсгөл эрчим хүч ХХК-ы дотоод хяналтын ажилтан нь тайлант онд хийх хяналт, шалгалтын ажлын тусгайлсан төлөвлөгөөг боловсруулж эрх бүхий ажилтнаар батлуулаагүй, хяналт шалгалт хийсэн ажлын тайлангүй байна. Энэ нь Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ын 3.4. Дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтан нь тухайн аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны онцлог, үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэл, хэмжээ, зохион байгуулалтын бүтэц, харьяалагдах нэгж, объектын тоог харгалзан тухайн жилд хийх хяналт шалгалтын ажлын тусгайлсан төлөвлөгөөг боловсруулан эрх бүхий албан тушаалтнаар батлуулан мөрдөж ажиллана, 4.1. Дотоод хяналт шалгалтыг дараах чиглэлээр зохион байгуулна: гэсэнтэй тус тус нийцэхгүй, "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.
3. Хөвсгөл эрчим хүч ХХК нь ахмадын сан байгуулж ажиллаагүй байна. Энэ нь Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7 "Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах бөгөөд Ахмадын сан байгуулан ажиллуулах журмыг Засгийн газар батална" заалттай нийцэхгүй, "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

5.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Төлөөлөн Удирдах зөвлөлд:

1. Тогтоол шийдвэртэй холбоотой

- 1.1. Илрүүлэлт: Тайлант онд тус компанийн зорилтот түвшнийг 4 удаа тодотгож баталсан ба энэ нь санхүүгийн үйл ажиллагааг тогтворгүй болгох, санхүүгийн сахилга батыг алдагдуулах эрсдэлтэй ба ТУЗ-ийн Аудитын хороо нь холбогдох хяналтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Энэ нь компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.4. "Энэ хуулийн 81.2-т заасан аудитын хорооны дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн байх бөгөөд уг хороо нь дараах чиглэлээр дүгнэлт гаргаж, төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулна" заалттай нийцэхгүй, Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- 1.2. Өгсөн зөвлөмж: Зорилтод түвшнийг батлахдаа тооцоо судалгаанд үндэслэн баталж, хэрэгжилтэд хяналт тавих

Хөвсгөл Эрчим хүч ХХК-ийн гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч, холбогдох ажилтнуудад:

2. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой

- 2.1 Илрүүлэлт: Өр төлбөрийн дэлгэрэнгүй журналыг хянан үзэхэд Мэйжүрмэнт ХХК-д өгөх өр төлбөрийн эхний үлдэгдэл хасах 5.8 сая төгрөг байх ба энэ дүнгээр нийт өрийг бууруулж тайланд тусгасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4. үнэн зөв байх; гэсэн заалттай нийцэхгүй, "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

- 2.2 Өгсөн зөвлөмж: Өр төлбөрийг 2025 оны санхүүгийн тайланд залруулан бүртгэх

3. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой

3.1 Илрүүлэлт: Шатахууны зарцуулалтад түүвэрлэн хяналт хэрэгжүүлэхэд жолоочийн тооцооны хуудсыг нягтлан бодогчоор бодуулж, холбогдох албан хаагчаар баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5. Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2 Өгсөн зөвлөмж: Жолоочийн тооцоог тухай бүр бодож, баталгаажуулах

4. Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой

4.1 Илрүүлэлт: Тайлант онд албан хаагчдад олгосон албан томилолтыг хянаж үзэхэд албан томилолтоор ажилласан албан хаагчдын дансанд тус бүрд биш нийт дүнгээр нь нэг албан хаагчийн дансанд шилжүүлж байна.

4.2 Өгсөн зөвлөмж: Албан томилолтоор ажилласан албан хаагч тус бүрийн дансанд томилолтын зардлыг хийж, тооцоог бодох

5. Өмнөх аудитын зөвлөмжийн хэрэгжилттэй холбоотой

5.1 Илрүүлэлт: Хөвсгөл аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 06 сарын 14-ний өдрийн 155/ШШ2021/00638 дугаар тушаалаар В.Чулуунд 3.5 сая төгрөгийг олгосон ба тус мөнгийг буруутай албан тушаалтнаар төлүүлээгүй байна. Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1 "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай этгээдээр буцааж төлүүлнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна

5.2 Өгсөн зөвлөмж: Буруутай шийдвэр гаргасан албан тушаалтнаас төлбөрийг төлүүлж, байгууллагыг хохиролгүй болгох

6. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой

6.1 Илрүүлэлт: Тайланд онд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгийн зарлагын 145 гүйлгээний 1,600.8 сая төгрөгийн мэдээллийг мэдээлээгүй. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4. Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ: 6.4.5. цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр, заалттай нийцэхгүй байгаа ба "нийцсэн бөгөөд зохистой" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

6.2 Өгсөн зөвлөмж: Шилэн дансны системд мэдээллийг үнэн зөв, бүрэн гүйцэт мэдээлж байх

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг аудитын тайлан хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 20 -ны өдрийн дотор тус тус Төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/			
							Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
							Тоо	Дүн	Тоо	Дүн
Өр төлбөрийг буруу илэрхийлсэн	1	5,858.9			1	5,858.9			1	5,858.9
Дүн	1	5,858.9			1	5,858.9			1	5,858.9

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Жолоочийн тооцоо бодоогүй	1	-					1	-				
Анхан шатны баримтгүй	1	1,186.0	1	1,186.0								
албан томилолтоор ажилласан албан хаагчдын дансанд нь томилолтын зардлыг шилжүүлдэггүй	1	-					1	-				
Зориулалт бусаар зарцуулсан	1	9,300.0	1	9,300.0								
Дотоод хяналт хангалтгүй	1	-			1	-						
Зөрүүгийн тайлан бэлтгээгүй.	1	-					1	-				
ЗЕХ-ийн 103.1	1	3,528.5					1	3,528.5				
	7	14,014.5	2	10,486.0	1	-	4	3,528.5	-	-	-	

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил										
Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчсөн.	1	1,700.0	1	1,700.0						
ТУЗ-ийн тогтоол шийдвэртэй холбоотой	2	13,200.0	1	13,200.0					1	
ХАА-тай холбоотой	1	0					1	0	0	-
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой	1	1,600,894.3							1	1,600,894.3
Ахмадын сан байгуулаагүй	1						1	0		
Дүн	6	1,615,794.3	2	14,900.0	2	0	2	0	2	1,600,894.3